

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аудит хийх үндэслэл: Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын нэр:

2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц



Төсвийн захирагчид холбогдох хууль, журмын дагуу төсвийн төслийг боловсруулаагүй, ИТХ төсвийн зарлагыг нэмэгдүүлэх замаар орлогыг нэмж баталсан байна.

Баруун-Урт сум
2018 он

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

Сүхбаатар аймаг
дахь Төрийн
аудитын газрын
дарга, тэргүүлэх
аудитор М.Нарантуяа

Аудитын
менежер Г.Даваа

Аудитор О.Барчидгүнсэн
Аудитор Ө.Золзаяа

2018 оны 10 дугаар сарын 29-ны
өдөр

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал багийн утас 70512123,
70512127

Газрын дарга, тэргүүлэх аудитор
70518396 дугаарын факсаар
харилцана уу

ХАЯГ:

Сүхбаатар аймаг дахь Төрийн
аудитын газар, Баруун-Урт сум, 7-р
баг, Нутгийн удирдлагын ордон,
өрөө №226 тоот

Сүхбаатар аймаг
Баруун-Урт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,
шалгуур үзүүлэлт

Товчилсон үгийн тайлбар

Бүлэг 1. Төсвийн орлогыг тооцоо судалгаагүй, үндэслэлгүй төлөвлөх, зарлагаа нэмэгдүүлэх замаар орлогоо өсгөж баталсан байна

- 1.1 Аймгийн 2018 оны төсвийн төсөл хуулиар тогтоосон зарим шалгуурыг хангахгүй байна
- 1.2 Төсвийн орлогыг зарлагаа өсгөх зорилгоор нэмж баталжээ
- 1.3 Аймгийн 2018 оны төсвийг алдагдалгүй баталсан хэдий ч зарим нэр төрлийн орлого тасрах эрсдэлтэй байна

Бүлэг 2. Аймгийн төсвийн орлого 2018 оны жилийн эцэст тасрах эрсдэлтэй байгаа бөгөөд батлагдсан хөтөлбөр арга хэмжээ, зарлагаа санхүүжүүлэх эх үүсвэргүй болж, төсөв алдагдалтай гарахаар байна

- 2.1 Аймгийн төсөвт төвлөрөх орлого 630.1 сая төгрөг буюу 10.7 хувиар тасарсан байна
- 2.2 Төсвийн байгууллагуудад өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломжгүй байна

Бүлэг 3. Төсөв батлагдаагүй байхад 10,619.6 сая төгрөгийг зарцуулж Төсвийн тухай хуулийг зөрчжээ

- 3.1 Аймгийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаар төсвийн гүйцэтгэл 35,961.2 сая төгрөг байна.
- 3.2 Төсөв батлагдаагүй байхад 10,619.6 сая төгрөгийг зарцуулж Төсвийн тухай хуулийг зөрчжээ

Бүлэг 4. Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг ИТХ-д төсвийн төслийн хавсралтаар оруулж батлуулаагүй байна

- 4.1 Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг ИТХ-д төсвийн төслийн хавсралтаар оруулж батлуулаагүй байна
- 4.2 Төсвийг оновчтой тооцон хуваарилдаг тэгш шударга, ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна

Аудитын дүгнэлт:
Аудитын зөвлөмж:
Холбогдох байгууллагын санал
Аудитын газрын тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Аудитын зорилтын хүрээнд дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, дүгнэлт өгөв. Үүнд:

- ✓ 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх
- ✓ 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- ✓ 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх
- ✓ ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх

Аудит хамарсан хүрээ

Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон сумын захиргааны байгууллага, төсвийн байгууллагууд болон ОНӨААТҮГ-ын 2018 оны 09 дүгээр сарын байдлаар санхүүгийн баримт материал, орон нутгийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, тайлан тэнцэл, судалгаа, бодлогын бичиг баримт, үйл ажиллагааны холбогдох баримт материалыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 7,184.2 сая төгрөгөөр, хүн амын орлогын албан татварын буцаан олголтонд 671.5 сая төгрөг олгохоор тооцож нийт татварын болон татварын бус орлогыг 11,111.2 сая төгрөгөөр баталж,

гүйцэтгэлээр татварын орлого 7,726.8 сая төгрөг төвлөрч орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 107.5 хувийн биелэлттэй гарсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт урсгал зардалд 50,965.8 сая төгрөгийг зарцуулжээ. 2017 онд батлагдсан төсөвтэй харьцуулахад 95.7 хувийн гүйцэтгэл гарсан байна.

Нийт гүйцэтгэлийн 71 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 0.4 хувийг татаас, 16.4 хувийг урсгал шилжүүлэг, 10.4 хувийг хөрөнгийн зардал, 1.8 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлд тус тус зарцуулсан байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НӨАТУС	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын сугалаа
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Дэд зорилт-1. Монгол Улсын 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх

1

БҮЛЭГ 1

Төсвийн орлогыг тооцоо судалгаагүй, үндэслэлгүй төлөвлөх, зарлагаа нэмэгдүүлэх замаар орлогоо өсгөж баталсан байна

1.1 Аймгийн 2018 оны төсвийн төсөл хуулиар тогтоосон зарим шалгуурыг хангахгүй байна.

1.1.1 Аймгийн ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1¹, 31.4², 33 дугаар зүйлийн 33.2³, 67 дугаар зүйлийн 67.1⁴ дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.2, 7.5–ын дагуу аймгийн Засаг дарга тухайн шатны төсвийн төслийг боловсруулж, танилцуулгын хамт Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлэх чиг үүрэгтэй. Сүхбаатар аймгийн ТЕЗ 2018 оны төсвийн төслийг боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлж, 2018 оны 09 дүгээр тогтоолоор батлуулсан боловч дараах шаардлагыг бүрэн хангаагүй байна. Үүнд:

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдээгдэлд суурилсан ТЕЗ-ийн жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалттай нийцэхгүй байна.
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.3⁵ -д заасан хугацаанд аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн төслийг тус аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлээгүй.
- Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1⁶, 8.5.2⁷-т заасан цаглабарын дагуу тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулаагүй байна. Энэ нь аймгийн ИТХ-д суудалтай намуудын улс төрийн маргаантай байдлаас шалтгаалан орон нутгийн төсөв цаг хугацаандаа батлагдаагүй байна.
- Төсвийн захирагч бүрийн хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулаагүй
- Аймгийн 2018 оны төсвийн төслийн танилцуулгад Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 67 дугаар зүйлийн 67.2, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасны дагуу зарим тооцоо судалгааг иж бүрэн боловсруулж, өргөн мэдүүлээгүй байна. Тухайлбал: орон нутгийн макро эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ, ирээдүйн чиг хандлагын төсөөлөл, тооцоо, төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг тооцсон байдал, төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ, төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн

¹ Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна

² Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана

³ Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална

⁴ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ

⁵

⁶ аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх

⁷ аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах


гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөлөл, хөтөлбөр, арга хэмжээнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, Төсвийн тусгай шаардлагад болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж байгаа талаарх тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулгыг бэлтгээгүй өргөн мэдүүлсэн байна.

1.1.2 Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1 –д заасан хугацаанд нь батлаагүйгээс сумдын ТТЗ-ийн төсөв хуулийн хугацаанд батлагдаагүй байна. Сумдын ТТЗ төсвийн төслийг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” болон Төсвийн тухай хуульд заасан шалгуурыг иж бүрэн хангаж, төлөвлөөгүй байна. Мөн 2018 оны төсвийн төслийг төсвийн удирдамж, тухайн жилд баримтлах бодлого чиглэлийг тодорхойлоогүйгээр ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулжээ.

1.1.5 Засгийн газар, аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 оны хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, аймаг, сумдыг хөгжүүлэх хэтийн зорилт, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төсвийн дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын зорилтыг тодорхойлох, төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан ангилал, хөтөлбөр арга хэмжээгээр төлөвлөх, чанарын болон тоон үзүүлэлтээр хүрэх үр дүнг тооцож Төсвийн болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлага үүссэн байна.

1.2 Төсвийн орлогыг төсвийн зарлагаа өсгөх зорилгоор нэмж баталжээ.

1.2.1 Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас аймгийн суурь орлогыг 8,159.7 сая, нийт орлогыг 8,442.5 сая төгрөгөөр тооцож орлогын доод хязгаарыг тогтоожээ. Аймгийн ТЕЗ суурь орлогод үндэслэн 2018 оны төсвийн төсөлд татварын болон татварын бус орлого 8,660.0, хандив тусламж, бусад орлого 2,996.0 сая нийт 11,656.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Аймгийн төсвийн нийт орлогыг суурь орлоготой харьцуулахад 3,496.3 сая төгрөгөөр илүү төвлөрөхөөр төлөвлөсөн



бөгөөд ХХОАТ-ыг 100.0 сая, хөрөнгийн албан татвар 215.0 сая, газрын төлбөр 35.0 сая, усны нөөц ашигласны төлбөр 379.0 сая, хүү, хөрөнгө борлуулсны болон бусад орлогыг 2,775.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, түрээсийн болон төсөвт байгууллагын өөрийн орлогыг 5.7 сая төгрөгөөр бууруулсан байна. Мөн ТЕЗ-ийн орлогын саналыг ИТХ хэлэлцээд ХХОАТ 100.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 5.0 сая, бусад орлогыг 700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогыг 12,461.0 сая төгрөгөөр баталжээ. Орлогыг ямар эх үүсвэрээс төвлөрүүлэх нь тодорхойгүй

нэмэгдүүлсэн, зөвхөн өмнөх оны гүйцэтгэлийг баримтлах болон төсвийн зарлагаа нэмэгдүүлэх чиглэлээр орлогыг өсгөж баталсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2⁸-д заасан төсвийн зарчимтай нийцэхгүй байна. Төсвийн орлогыг тооцоо судалгаагүй, үндэслэлгүй төлөвлөх, зарлагаа нэмэгдүүлэх замаар орлогоо өсгөж баталсан эрсдэл нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д заасны дагуу

⁸жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх

Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийг зогсоох хүртэл арга хэмжээ авах нөхцөл байдал үүсэхээр байна. Мөн аймгийн төсвийн орлого тасрах эрсдэлтэй байгаа бөгөөд батлагдсан хөтөлбөр арга хэмжээ, зарлагаа санхүүжүүлэх эх үүсвэргүй болж, төсөв алдагдалтай гарахаар байна. /Хүснэгт №1 Орлогын төлөвлөгөө, хуваарь/

1.2.2 Аймаг, сумдын төсвийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн, бодитой төлөвлөх, төсвийн орлогод учирч болзошгүй эрсдэлийг тооцон, боломжит эх үүсвэрийг дайчлах, төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.2.3 Аймгийн ИТХ-ын 2018 оны 09 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлого 8,960.0 сая, хандив тусламжийн орлого 3,450.0 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 30.0 сая, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 6,961.2 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 2,666.1 сая, тусгай зориулалтын шилжүүлэг 29,200.4 сая, тусгай шилжүүлгийн төсөвт байгууллагын өөрийн орлогыг 116.2 сая, өмнөх оны үлдэгдлээс 701.6 сая нийт 52,006.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр баталсан байна.

1.2.4 Аймгийн 2018 оны төсвийн зарлагыг 52,006.4 сая төгрөгөөр баталснаас аймгийн ИТХ, ЗДТГ болон орон нутгийн төсвийн байгууллагын урсгал зардалд 3,302.3 сая, хөрөнгийн зардалд 6,225.2 сая, сумдын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 3,939.9 сая төгрөг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1,086.4 сая, тусгай зориулалтын шилжүүлэг 29,216.4 сая, өвөлжилтийн бэлтгэл хангах үйл ажиллагаанд 1,185.0 сая, хувь хүний орлогын албан татварын буцаалт 570.0 сая, тусгай сан болон бусад хөтөлбөр үйл ажиллагааны зардалд 6,481.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 -д заасны дагуу төсвийн шууд захирагчид төсвийн төслийг холбогдох аргачлал, заавар журмын дагуу боловсруулж дээд шатны төсөв захирагчид хүргүүлэх үүрэгтэй. Гэтэл төсвийн байгууллага, төсвийн шууд захирагч нар төсвийн төслөө боловсруулж, дээд шатны төсвийн захирагчдаа хүргүүлээгүй төсөв хөрөнгө батлагдаж байгаа нь дээрх хуулийн заалттай нийцэхгүй байна. ТЭЗ анхан шатны нэгжээс төсвийн төлөвлөлтийн талаарх тооцоо судалгаа авч, төсвийн төлөвлөлтийг боловсруулахгүй байгаа нь нэг талаас хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх нөгөө талаас доод шатны төсөв захирагчийн төсвийн төсөл, бодлого чиг үүргийн талаар хангалттай бус мэдээлэлтэй төсвийг төлөвлөх эрсдэлтэй байна. Мөн төсвийн орлого, зарлагын суурь тооцоолол, өмнөх оны гүйцэтгэл, нэгдсэн нэг бодлого төлөвлөлтийг хийхэд хүндрэл үүсэхээр байна.

1.3 Аймгийн 2018 оны төсвийг алдагдалгүй баталсан хэдий ч зарим нэр төрлийн орлого тасрах эрсдэлтэй байна.

1.3.1 Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2⁹ дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2.1.1, 7.1.2¹⁰-д заасны дагуу ТЭЗ-ийн 2018 оны төсвийн орлого, зарлагыг 52,006.4 сая төгрөгөөр төсвийг алдагдалгүй баталжээ. Аймгийн төсвийн орлогод хандив, тусламж, бусад орлого 2018 оны 09 дүгээр сарын байдлаар 630.1 сая төгрөгөөр тасарч байгаа бөгөөд тухайн жилд төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ гэж тооцвол төсөв алдагдалтай гарах эрсдэлтэй байна.

⁹ Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ

¹⁰ төсвийн тэнцэл алдагдалгүй байх

Дэд зорилт-2. 2018 оны батлагдсан төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх


2

БҮЛЭГ 2

Аймгийн төсвийн орлого тасрах эрсдэлтэй байгаа бөгөөд батлагдсан хөтөлбөр арга хэмжээ, зарлагаа санхүүжүүлэх эх үүсвэргүй болж, төсөв алдагдалтай гарахаар байна

2.1 Аймгийн төсөвт төвлөрөх 2018 оны 3 дугаар улирлын байдлаар орлого 630.1 сая төгрөг буюу 10.7 хувиар тасарсан байна.

2.1.1 Аймгийн хэмжээнд 2018 онд улс, орон нутгийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 12,215.8 сая төгрөгөөр төлөвлөжээ. 2018 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 8,024.4 сая төгрөгийн орлого төвлөрөхөөс 9,305.0 сая төгрөг төвлөрч 16 хувиар давсан байна. Үүнээс улсын төсөвт төвлөрөх орлого 1,252.8 сая төгрөг буюу 140



хувиар, сумдад төвлөрүүлэх төсвийн орлого 658.0 сая төгрөг буюу 53.8 хувиар тус тус давж биелэсэн бол, аймагт төвлөрүүлэх орлого 630.1 сая төгрөг буюу 10.7 хувиар тасарсан байна. Улсын төсвийн орлого төлөвлөснөөс 2.4 дахин их орлого төвлөрсөн нь НӨАТУС-н хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор ногдол өссөн, цайр, жонш, төмрийн хүдэр, нүүрсний

үнэ, ханшийн өсөлтөөс шалтгаалан уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаагаа идэвхжсэнтэй холбоотой байна. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийг Мөнххаан, Уулбаян сумд 26.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр Баяндэлгэр 6.4 сая, Дарьганга 38.4 сая, Мөнххаан 121.6 сая, Сүхбаатар 0.4 сая, Түвшинширээ 12.8, Уулбаян 142.8 сая, Халзан 6.4 сая нийт 328.8 сая төгрөг төвлөрч 302.0 сая төгрөгөөр тус орлого давж биелэжээ. Галт зэвсгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газар, усны нөөц, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого гүйцэтгэлээр 43.3-72.4 хувиар тасарч байна. Тухайлбал: Асгат, Баруун-Урт, Дарьганга, Мөнххаан, Түвшинширээ, Халзан, Эрдэнэцагаан сумдын галт зэвсгийн албан татварын гүйцэтгэл 11.7-30.4 хувь, Онгон, Эрдэнэцагаан сумдын ТТАМНАТ-ийн гүйцэтгэл 0 хувь, Асгат, Халзан сумын газрын төлбөрийн гүйцэтгэл 16.9-17.7 хувь, Уулбаян сумын улсын тэмдэгтийн хураамж 24.9 хувь, Онгон сумын ус рашаан ашигласны төлбөрийн гүйцэтгэл 15 хувь, Түмэнцогт, Түвшинширээ, Уулбаян, Халзан сумдын суутгагчийн хувь хүнд олгосон албан татварын гүйцэтгэл 1.9-37.7 хувьтай төвлөрсөн байна. Иймд дээрх сумдын төсөв захирагчид тасрах эрсдэл байгаа төсвийн орлогуудад онцгой анхаарч арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Төсвийн нийт орлогын төлөвлөлтийг үнэлэхэд жилийн эцэс болоогүй, гүйцэтгэлийг урьдчилсан байдлаар гаргах боломжгүй байгаа бөгөөд цаашид орлогын бааз суурь, тооцооллыг сайжруулах, орлогыг бодитой төлөвлөх шаардлагатай байна. Тухайлбал:

- Цалин болон түүнтэй адилтгах орлогод ногдуулах албан татварын шатлал бүрд хамрагдах хөдөлмөр эрхлэгчдийн тоо, цалингийн санг 2016 оны гүйцэтгэл, 2017 оны хагас жилийн байдлаар гаргаж төсвийн орлогын төсөөллийг боловсруулахад ашиглах
- Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын орлогыг тооцоход шаардагдах мэдээллүүдийг холбогдох банк, санхүүгийн байгууллагуудаар гаргуулж, эдгээр мэдээлэлд үндэслэн төсвийн орлогын тооцооллыг боловсруулах
- Төсвийн орлогын төлөвлөлтийг эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн таамаглалтай уялдуулах.
- Тооцоо судалгаагүй, бодитой бус орлого төлөвлөхгүй байхад онцгой анхаарах
- Хүү торгуулийн болон Суутган-4 албан татваруудын дата бааз, мэдээллийн өгөгдлийг бодитой боловсруулах
- Орлогыг төвлөрүүлэхэд эрсдэл үүсгэх дотоод, гадаад хүчин зүйлд шинжилгээ хийж, нөхцөл байдалд тохирсон арга замыг эрэлхийлэх
- Орлого тус бүрийн өмнөх 2 оны гүйцэтгэл, өмнөх оноос тухайн орлогыг бууруулсан болон нэмсэн шалтгааныг тооцоо судалгааны үндэслэлтэй төсвийн танилцуулгад толилуулж, төсвийн төслийг ИТХ-д өргөн мэдүүлж байх
- Уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэл, олборлолтын төлөвлөгөөнд үндэслэн татварын орлогыг бодитой тооцох
- Ангилагдаагүй, бусад орлого нэрийн дор төсвийн орлогыг тодорхойгүй байдлаар төлөвлөхгүй байх нь төсвийн орлогын төлөвлөлтийг сайжруулах боломжтой юм.

2.2 Орон нутгийн төсөвт 2018, 2019 онд 46.6 сая төгрөгийн ногдол ашгийн орлого төвлөрөхөөр байна.

2.2.1 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.9.1 -д заасны дагуу “Хайлааст-Голомт”, “Онгон-Арвижих” ОНӨҮГ-уудын цэвэр ашгаас Сүхбаатар, Ongon сумдад төсвийн орлого нэмэгдэх боломжтойг тооцоолон харьяалах Төсвийн төвлөрүүлэн захирагч нартай зөвлөлдсөн бөгөөд ОНӨҮГ-тай байгуулсан гэрээг өөрчлөх, сум орон нутгийн төсвийн орлогод ногдол ашиг хуваарилах заалт оруулж, төсвийн орлого бүрдүүлэхээр боломжтой байна. “Онгон-Арвижих” ОНӨҮГ нь 2017 оны санхүүгийн тайлангаар 48.6 сая төгрөгийн цэвэр ашиг, 49.7 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй, “Хайлааст-Голомт” ОНӨҮГ 7.9 сая төгрөгийн цэвэр ашигтай бөгөөд элэгдэл хассан ашиг 42.9 сая төгрөг, 91.2 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй тус тус ажиллажээ. Иймээс 2018, 2019 оны орон нутгийн төсөвт 46.6 сая төгрөгийн ногдол ашгийн орлого төвлөрөхөөр байна.

---oOo---

Дэд зорилт-3. 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх

3

БҮЛЭГ 3

Төсөв батлагдаагүй байхад 10,619.6 сая төгрөгийг зарцуулж Төсвийн тухай хуулийг зөрчжээ

3.1 Аймгийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаар төсвийн гүйцэтгэл 35,961.2 сая төгрөг байна.

3.1.1 Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн 2018 оны 3-р улирлын байдлаар батлагдсан төсөв 45,430.7 сая төгрөг, нийт гүйцэтгэл 35,961.2 сая төгрөгийн зарлага гарчээ. Төсвийн батлагдсан төлөвлөгөө болон гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд урсгал зардал 5,138.2 сая, хөрөнгийн зардал 3,316.8 сая, эргэж төлөгдөх цэвэр зээл 1,014.5 сая нийт 9,469.5 сая төгрөгийн төсөв хэмнэгдсэн харагдаж байна.

Урсгал зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт Хэтрэлт	Хувь
Цалин хөлс нэмэгдэл урамшил	16,030.6	15,281.0	-749.6	95.6
АО-с нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,919.6	1,836.9	-82.7	94.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,299.3	2,605.3	-694.0	78.8
Хангамж, бараа материалын зардал	734.9	623.6	-111.3	84.8
Нормативт зардал	1,450.0	1,233.5	-216.5	84.8
Эд хогшил урсгал засварын зардал	411.5	256.5	-155.0	62.3
Томилолт, зочны зардал	148.5	94.6	-53.9	63.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,393.0	859.5	-533.5	61.7
Бараа үйлчилгээний бусад зардал	3,699.3	2,459.0	-1,240.3	67.6
Татаас	840.3	784.9	-55	
Урсгал шилжүүлэг	8,831.1	7,585.1	-1,246.0	

Төсвийн зарлагын хэмнэлтийн шалгааныг авч үзвэл:

- Тусгай зориулалтын шилжүүлгийн зарим байгууллагуудын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны дэмжлэг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүй тул тухайн зардал хэмнэлтэй байна. Өөрөөр хэлбэл хүлээгдэж буй гүйцэтгэлээр бүрэн зарцуулагдахаар байна.
- Урсгал зардлын хэмнэлт нь цаг үеийн байдалтай холбоотойгоор дараагийн саруудад хүлээгдэж буй гүйцэтгэлд зарцуулагдахаар байна. Тухайлбал: Аймгийн хэмжээнд гамшгийн онц байдал зарласан бөгөөд Эрдэнэцагаан, Асгат, Сүхбаатар гэх мэт сумд бэлтгэл байдлын шалгалт, нүүлгэн шилжүүлэлт, үзүүлэх сургалтын улмаас 9-р сарын ажил гүйлгээг дараагийн сард шилжүүлсэн байна.
- Тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн хуваарийг алдаатай боловсруулсан байна. Эхний сарууд дээр төсвийг их, дараагийн саруудад бага хуваарилах гэх мэт төсвийн хуваарийн хэлбэлзлүүд үүссэнтэй холбогдуулан төсөв хэмнэгдэх, хэтрэх байдлаар харагдаж байна. Тухайлбал: Төвлөрсөн халаалтад холбогдсон сургууль цэцэрлэгүүдийн түлш халаалтын зардлын сар, улирлын хуваарилалтад дүн шинжилгээ хийлээ. Тухайн байгууллагын түлш халаалтын зардлын 2018 оны батлагдсан төсвийг эхний 4 сарын байдлаар Баруун-Урт сумын 11 дүгээр цэцэрлэг 11.3 сая, 3 дугаар цэцэрлэг 16.7 сая, Түмэнцогт сумын цэцэрлэг 6.4 сая, Баруун-Урт сумын 1 дүгээр сургууль 25.0, сая, 2 дугаар сургууль 17.0 сая, 3 дугаар сургууль 21.7

сая, 4 дүгээр сургууль 20.1 сая төгрөгийг тус тус илүү, Дарьганга 7.4 сая, Онгон 6.7 сая, Сүхбаатар 1.6 сая, Баруун-Урт сумын 2 дугаар цэцэрлэгт 4.2 сая, Түмэнцогт сумын сургууль 62.0 сая, Халзан сумын сургууль 6.0 сая, Сүхбаатар сумын сургууль 2.5 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна. /Хүснэгт 2, 3. Түлш халаалтын зардлын сарын хуваарилалт/

Дээрх байдлаас харахад бодит бус хэмнэлт бөгөөд дараагийн саруудад хүлээгдэж буй гүйцэтгэлд зарцуулагдахаар харагдаж байна.

3.2 Төсөв батлагдаагүй байхад 10,619.6 сая төгрөгийг зарцуулж Төсвийн тухай хуулийг зөрчжээ.

3.2.1 Сүхбаатар аймгийн ТЭЗ-ийн төсвийн жил эхлэхэд аймгийн ИТХ-аар төсвөө батлуулаагүй нөхцөл байдал үүссэн. Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 02 дүгээр сарын 08-ны өдрийн А/34 тоот захирамж гарч, Төсвийн тухай хуулийн 41.4, 41.6 дахь заалтуудыг үндэслэн төсвийн жил эхлэхэд төсөв батлагдаагүй нөхцөл байдал үүсвэл төсвийн санхүүжилтийн түр горимыг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан боловч Төсвийн тухай хуулийн 41.4.1, 41.4.2 дахь заалтуудыг мөрдөөгүй цалин, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг өмнөх оны түвшинд санхүүжүүлэхээр захирамж гаргасан нь уг хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн. Манай байгууллагаас дээрх зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй байхад 2018 оны 4 дүгээр сарын байдлаар 10,619.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж, Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.2.2 Аймгийн ИТХ Орон нутгийн хөгжлийн санд өмнөх оноос шилжиж ирсэн бараа, ажил, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,458.2 сая төгрөг, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтад 3,364.9 сая нийт 4,823.1 сая төгрөг баталсан байна. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, зураг төсөл, төсөв боловсруулахад 349.0 сая, техник, тоног төхөөрөмж 300.0 сая төгрөг, худаг, уст цэг байгуулах 90.0 сая, нийтийн эзэмшлийн талбай, гэрэлтүүлгийн засвар шинэчлэл 419.8 сая төгрөг хуваарилсан байна. Аймаг, сумд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж, шилэн дансанд мэдээлсэн ба худалдан авах ажиллагааны урилгыг www.tender.gov.mn сайтад байршуулжээ. Харин Асгат сумын багийн төвийн барилга угсралтын 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1¹¹, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “ТБОНӨХБАҮХА ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ батлах тухай журам”-ыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

3.2.3 Сумын эрүүл мэндийн төвүүдэд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг аймгийн ЭМГ-аас 15 багцын 116.6 сая төгрөгт багтаан зарлажээ. Хамгийн бага үнийн санал ирүүлсэн гүйцэтгэгчтэй 104.4 сая төгрөгөөр гэрээ байгуулсан боловч 9 багцыг зарласан босго үнээс их дүнгээр гэрээ байгуулсан, багц бүрийн эм, эмнэлгийн хэрэгслийг нэр төрөл, тоо хэмжээ, үнийг гэрээний хавсралтаар батлуулаагүй, эм эмнэлгийн хэрэгслийн захиалга, хуваарилалт зөрүүтэй байна. Тендерийн эм, эмнэлгийн хэрэгслийн хуваарилалт, зарцуулалтад дотоод хяналтыг шат шатандаа хэрэгжүүлэхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг зөрчжээ. Тухайлбал: Асгат, Баяндэлгэр, Мөнххаан, Түмэнцогт, Эрдэнэцагаан сумдын ЭЭС-ууд өөрийн болон

¹¹ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна

тендерийн эм, эмнэлгийн хэрэгслийг хамтад нь хадгалснаас тендерийн эмийн үлдэгдэлд тооллого хийж, тулган баталгаажуулах боломжгүй байна. Дээрх хууль тогтоомж зөрчсөн алдаа дутагдалд төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлагыг ЭМГ-ын даргад хүргүүлээ.

3.2.4 Аудитын явцад сургууль, цэцэрлэгүүдийн цалин, хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хоол, нэг удаагийн тэтгэмжийн зардлуудыг анхан шатны болон бусад баримтуудаар тулган баталгаажуулж, тухайн байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнуудтай уулзалт, ярилцлага, тэмдэглэл хийлээ. Үүнд:

- Баруун-Урт сумын 10 дугаар цэцэрлэгийн хоолны зардлыг хүүхдийн ирцийн бүртгэл, хоолны өдөрлөгтэй тулгаж, 1 хүүхдэд ноогдох норм нормативаар тооцоход хүүхдийн ирцийг илүү бүртгэсэн зөрүү 3.1 сая төгрөгт төлбөрийн акт тогтоолоо.

Дэд зорилт-4. ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцсэн эсэх

4

БҮЛЭГ 4

Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг ИТХ-д төсвийн төслийн хавсралтаар оруулж батлуулаагүй байна

4.1 Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг ИТХ-д төсвийн төслийн хавсралтаар оруулж батлуулаагүй байна.


4.1.1 Засгийн газрын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасны дагуу төсөв захирагчдын хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн төсөлд хавсралт байдлаар оруулж батлуулаагүй байна.

4.1.2 Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг зохистой тогтоож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

4.2 Төсвийг оновчтой тооцон хуваарилдаг тэгш шударга, ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна.

4.2.1 Ерөнхий боловсролын сургуулиуд болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын зардлын сарын хуваарийг аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/313 тоот захирамжийн 5, 6 дугаар хавсралтаар баталсан байна. Төсөв шууд захирагчдын төсвийг хуваарилахдаа Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг баримтлаагүй байна. Тухайлбал: Баруун-Урт сумын ЕБС-уудын цалин хөлс, нэмэгдэл, хичээл үйлдвэрлэл, хоолны зардлуудыг норм нормативаар тооцоогүй.

4.2.2 Аймгийн хэмжээний ЕБС, СӨБ-ын байгууллагын төсвийг оновчтой тооцон хуваарилдаг тэгш шударга, ил тод механизмыг нэвтрүүлээгүй, ижил хүчин чадал, үйл ажиллагаа нь нэг төсвийн нэгжүүдэд харилцан адилгүй төсөв хуваарилсан байна. Тухайлбал: Баруун-Урт сумын цэцэрлэг, сургуулиудын түлш халаалтын зардлын хуваарилалт илүү, дутуу хуваарилсан байна. /Хүснэгт 2/ Графикаас харахад норм нормативын дагуу тооцсон түлш халаалтын жилийн зардлыг 2-р цэцэрлэг 7.3 сая, 3-р сургууль 8.0 сая, 4-р сургууль 7.3 сая төгрөгөөр тус тус дутуу, 3-р цэцэрлэг 29.3 сая, 11-р цэцэрлэг 48.4 сая, 2-р сургууль 42.0 сая төгрөгөөр тус тус илүү хуваарилжээ.



4.2.3 Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5-д заасны дагуу Төсвийн шууд захирагч бүрээр төсвийн хуваарийг боловсруулж, батлуулаагүй, төсөвт зохицуулалт хийх шийдвэр гаргаагүй байхад төсвийн мэргэжилтэн тусгай шилжүүлгийн зарим төсөвт албан байгууллагын түлш халаалтын зардлаас урсгал засварын зардалд 8.0 сая, цалингийн зардалд 54.0 сая төгрөгийг хуваарилсан зөрчил дутагдал илэрлээ. Төсвийг илүү, дутуу хуваарилсан, хуваарилалтыг алдаатай боловсруулсан, Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийг хангалтгүй хэрэгжүүлсэн СТСХ-ийн төсвийн мэргэжилтэнд хариуцлага тооцуулах саналыг дээд шатны удирдлагад нь хүргүүлжээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн төсөл Төсвийн тухай хуульд заасан зарим шаардлага, шалгуурыг бүрэн хангаагүй батлагдсан байна.
2. Төсвийн орлогын бааз, суурийг сайжруулах, өгөгдлийн сангуудын мэдээллийг олон эх сурвалжаас бүрдүүлж, судалгаа шинжилгээ хийн, бодитой төлөвлөх шаардлагатай байна.
3. Төсөвт албан байгууллагууд болон төсвийн захирагчид Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн төслийг боловсруулж, харьяа шатны төсөв захирагчдаа хүргүүлээгүй, төсвийн төлөвлөлтийн талаар тооцоо судалгааг бүрэн боловсруулаагүй байна.
4. Аймаг, сумдын төсвийн зарим нэр төрлийн орлого оны эцэст тасрах магадлалтай байна.
5. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, хөтөлбөр арга хэмжээг зохистой төлөвлөсөн боловч түүний хэрэгжилт, үйл явцад хяналт, үнэлгээ, шинжилгээ хийгдээгүй байна.


ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлсон чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төслийг хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, санхүүжүүлэх эх үүсвэр, төсвийн ангиллын дагуу тооцоо судалгаа, танилцуулгын хамт боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулах
- Төсвийн орлогын бааз суурийг нийгмийн даатгалын болон иргэн аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын дата баазтай, суурь тооцоо судалгаатай уялдуулах замаар орлогын төлөвлөлтийг бодитой боловсруулж, төлөвлөх
- Төсвийг зөв зохистой удирдах, үүссэн өр төлбөрийг төсвийн хуваарь, зарлагын хэтрэлт, хэмнэлттэй уялдуулан барагдуулах
- Төсөвт байгууллагуудын зарим төсөвт зардлуудын үр ашгийг дээшлүүлэх. Үүнд Нүүрс тээврийн хөлсний нормативыг бусад сумдын жишигтэй уялдуулан тогтоож төсөв хэмнэх, мөн хоол хүнсний зардлын өртөг зардлыг багасгах, бууруулах боломж байгаа эсэхийг судалж, гэрээгээр зохицуулан, хэмнэсэн хөрөнгийг илүү үр дүнтэй зүйлд зарцуулах
- ТЕЗ-ын хөтөлбөр арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтэд сар, улирал, хагас, бүтэн жилээр хяналт тавьж, гүйцэтгэлийг зохион байгуулах
- Төсвийн зарлагын тэгш бус хуваарилалтыг арилгах, төсвийн норм норматив, аргачлалыг баримтлан ажиллах, төсвийн үр ашиг,ил тод байдал хяналтыг сайжруулах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Аймгийн хэмжээнд сургууль цэцэрлэгүүдийн төсвийг Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6¹² –ын дагуу батлах

¹² төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах

САНАЛ


**МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

2018.11.13 № 1/1755
танай 2018.10.31 -ны № 273 -Т


☐ СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн хэмжээнд хийгдсэн “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц” аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын явцад манай ажил хариуцсан мэргэжилтнүүд холбогдох тайлбар, мэдээллийг өгсөн.


Бидний зүгээс Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн санхүү, төсвийг зохистой удирдан үнэн зөв, ил тод, хариуцлагатай байдлыг хангах чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Аудитын тайлангийн төсөлд тусгагдсан асуудлуудыг судлан зөрчил дутагдлыг засаж залруулан ажиллах болно.


Ж.ЭРДЭНЭБААТАР

0001004

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1 дэх заалтын дагуу Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитын тайлангийн төслийг хүргүүлсэн. Аймгийн Засаг дарга аудитын тайлангийн төсөлтэй танилцаж 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1755 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн саналд зарчмын зөрүүтэй санал ирээгүй ба дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн байна.



Тайлан бичсэн:

Хянасан:

Аудитор

О.Барчидгүнсэн

Тэргүүлэх аудитор

М.Нарантуяа

Аудитор

Ө.Золзаяа

Аудитын менежер

Г.Даваа